

ТА БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

УЦС баригдах нутгийн болон түүний нөлөөнд орох нутгийн хүн ам, иргэн бүр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажилд оролцож мэдээлэл авах ба өгөх, санал өгөх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ боловсруулахад оролцох эрх ба үүрэгтэй. МӨН байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний явцад **НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ байдлын үнэлгээ** гэж хийгдэх ёстой бөгөөд энэ хэсэгт та зайлшгүй оролцох шаардлагатай.

Учир нь нийгэмд хэрхэн нөлөөлөхийг тогтоож үнэлгээ өгөхийн тулд үнэлгээчид орон нутгийн нийгмийн байдлыг ойлгох, түүнд ямар нөлөө учирч болзошгүйг нутгийнхнаас асуухгүй ойлгох, болзошгүй нөлөөллийг үнэн зөв тогтоохгүй. Өнөөг хүртэл нийгмийн нөлөөллийн үнэлгээг зөвхөн эерэг нөлөө талаас нь харж “ажлын байр бий болно”, “зам тавина”, “эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдэнэ” гэсэн жижиг хэсэг оруулж ирсэн. Гэтэл УЦС, уурхай мэт том төслүүд ихээхэн хэмжээний газар эзэлдэг, мөн ус, бэлчээр, тариалангийн газрыг бохирдуулна, хүн амын эрүүл мэндэд бас нөлөөтэй, олон зуун ажиллах хүчин орж ирснээр нийгмийн тухтай байдал, замын осол, гэмт хэрэг нэмэгддэг талуудыг орхидог юм.

Гол орхигддог асуудал нь нутгийн хүн амын хэрэглэж буй ус, ой ба газрын эх үүсвэрт сөрөг нөлөө учирвал хэрхэн үнэлж нөхөх олговор олгох, хэд ямар бүлгүүдэд олгох, яаж олгох, яаж шалгаруулах, хангалттай эсэхийг хэрхэн хянаж дутагдлыг залруулж байх хэсэг асуудлууд юм. Жишээ: Оюу Толгойн уурхайн лицензтэй газарт Бор-Овоогийн задгай орсон байдаг. Үнэлгээ хийх явцад малчид оролцоогүй тул тэр задгай өвөл хамгийн сүүлд хөлдөж тэр нутгийн хүн ам, мал ба ан амьтныг цорын ганц усны эх үүсвэр байсныг тогтоогоогүй, зүгээр нэг задгай тул хиймэл задгай байгуулж өгнө гэж амлаад устгасан. Одоо энэ задгайн экологийн буюу тэр цорын ганц усны үйлчилгээг яаж сэргээх вэ, хаана байрлуулах вэ? Гэсэн ажил хэдэн жил яриастай, үйлчилгээг сэргээсэн юм байхгүй нутгийн амид бүхэн хохирсон хэвээр байгаа.

УЦС баригдахын тулд нэлээд хэмжээний зам, гүүр, агуулах, цементийн үйлдвэр, дулааны станц, ажилчдын орон сууц г.м. дэд бүтэд баригдана. Барилгын ажлыг хангах нэлээд олон уурхай ба карьер ашиглалтад орно. Эдгээрийг хаана хэрэгжүүлэх зөвшөөрөл олгох вэ гэдгийг үнэлгээний явцад хамгийн сөрөг нөлөө багатай газар олж тогтоож сонгох учиртай.

Үнэлгээний явцад таныг оролцуулахдаа дараах нөхцөлүүд бүрдүүлэх үүрэгтэй:

1. УЦС-ын төслийн нөлөөллийг үнэлэх ажлын даалгаврыг танилцуулж зөвлөлдөхуулзалтын зар танд дор хаяж **14 хоногийн өмнө хүрсэн байх ёстой.**
2. Зөвлөлдөх уулзалт хийх **газар хүрч очиход боломжтой дөт** газар хийгдэх ёстой.
3. УЦС-ын төслүүд болон дэд бүтцийн төслүүдийн тухай материалыг зөвлөлдөх уулзалт эхлэхээс **14 хоногийн өмнө** өгсөн байх ёстой.
4. Танилцуулах материал нь танд **ойлгомжтой хэллэг**, уншиж ашиглахад дөхөмтэй **хэлбэрээр** хийгдсэн байх ёстой.
5. Танилцуулах материал төслийн **эерэг ба сөрөг талуудыг үнэн зөв тусгасан тэнцвэртэй** буюу төсөлд хамаарах бүх мэдээллийг бүрэн тусгасан байх ёстой.
6. Хэрэв **та төслийн шууд нөлөөнд өртөх**: орон гэр, өвөлжөө хаваржааны нүүлгэлт, бэлчээр ба тариалангийн газар алдах, ойн ба усны нөөц ашиглах, бизнес эрхлэх боломжоо алдах бол таныг зөвлөлдөх уулзалтад **заавал оролцуулж санал авах үүрэгтэй.**
7. Зөвлөлдөх үеэр Төсөл хэрэгжүүлэгч тал төслүүдийг дэмжүүлэх гэж **элдэв хэлбэрээр ятгах, ухуулах, үүрэгжүүлэх, элдэв зүйл амлах** эсвэл **сүрдүүлэхгүй** байх үүрэгтэй. Та урьдчилж мэдээлэлтэй танилцаж санал бодлоо бусдын нөлөөнөөс чөлөөтэй илэрхийлэх, өөрийн үзэл бодлоор шийдвэр гаргах эрхтэй.

8. Дээрх зарчмуудын аль нэг зөрчдөж та саналаа нөлөөллийн үнэлгээнд эсвэл хэлэлцүүлгийн протоколд тусгуулж чадаагүй бол та хуулийн дагуу гомдол гомдол мэдүүлэх боломжтой.
9. Үнэлгээний ажлын зорилго нь сөрөг нөлөөллийг тогтоох, түүний саруулах, бууруулах болон нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийг боловсруулахад орших тул та **өөрийн болон орон нутгийн эрх ашгийг хамгаалахад чиглүүлэн саналаа илэрхийлэхэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.**

Асуух лавлах зүйлүүддээ заавал хариулт аваарай. “Судлаад хариу өгнө” гэж хариулаад гардаг нь хангалтгүй. Танаас “сөргөөр нөлөөлж болохгүй ямар ус, газар, түүхийн дурсгал эсвэл соёлын өв байгаа вэ?” гэж асуух ёстой. Түүнд нь та нутгийнхаа хүн амын амьжиргааны чухал нөөц: ус ба ойн нөөц, бэлчээр/тариалангийн газар, жуулчлааын үзэсгэлэнт газар, хамгаалагдах түүхийн, соёлын эсвэл шүтээн газруудын байршил, нэр усыг тодорхой өгч тэдгээр нь үнэн зөв бүртгэгдсэнийг шалгах хэрэгтэй. Үнэлгээний тайланг эцсийн болгохоос өмнө мөн дахиад нутгийн хүм амд танилцуулна. Тэгэхэд та нарын саналууд тусгагдсан эсэхийг нягтлан шалгах боломжтой.

ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛД ЮУ ТУСГУУЛАХ ВЭ?

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар (холбогдох хуулиудын жагсаалт хавсаргав) хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх тухай заалтуудыг Эгийн голын УЦС ба түүний дэд бүтцийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэхийг шаардах.

Нийгэм-эдийн засгийн эрсдлүүдийг үнэлүүлэх:

1. **Бэлчээр, тариалангийн газар алдагдсанаар үндэсний ХАА, МАА салбарын эдийн засагт учрах нөлөөлөл** үнэлэх даалгавар байхгүй. БОНБУ – бүсийн нөлөөллийн үнэлгээнд Эгийн голын УЦС барьснаар алдагдах бэлчээрийн хэмжээ тооцоогүй. Тариалангийн газрын хэмжээ УЦСба түүний дэд бүтэц тус бүрээр гаргуулж нийт алдагдах газрын хэмжээ тогоолгох бөгөөд сумын ХАА салбарын орлогод хэрхэн нөлөөлөх магадлалтай тухай үнэлгээ хийлгэх.
2. **Хүнсний тусгаар байдалд ХАА, МАА эдэлбэр газар бүрмөсөн алдагдах, үйлдвэрлэл буурах явдал хэрхэн нөлөөлөхийг үнэлэх** даалгавар байхгүй байна.
3. **ХАА, МАА үйл ажиллагаанаас сумын төсөвт орох орлогод хэрхэн нөлөөлөхийг үнэлэх** даалгавар байхгүй.
4. **Сум, багийн эдийн засаг, хүн амын орлогод хэрхэн нөлөөлөхийг үнэлүүлэх** байхгүй.
5. **ХАА, МАА үйл ажиллагаа буурснаар ажилгүйдэлд хэрхэн нөлөөлөхийг үнэлэх** даалгавар байхгүй.
6. **Ажилгүйдэл нэмэгдсэнээр аймаг, сумын нийгмийн тогтвортой хөгжил, аюулгүй байдал, гэмт хэргийн гаралтад хэрхэн нөлөөлөхийг үнэлэх** даалгавар байхгүй байна.
7. **Нүүлгэн шилжүүлэх газрыг тогтоосны дараа тэр газарт тулгуурлан нөлөөллийн үнэлгээ хийлгэх.** Нүүлгэн шилжүүлэхийн үндсэн зарчим нь хүн амын амьжиргаа доройтуулахгүй, нүүсний дараа түр доошилсон бол богино хугацаанд хуучин түвшиндээ хүрч сэргэсэн байх ёстой. Тиймд, шинээр баг байгуулах газрын бэлчээр, тариалангийн газрын хүртээмж ба чанар, унд ба малын усны хүртээмж, чанар ямар байхаас нөлөөлөл ямар байх нь тодорхой болно. Нөлөөллийг зөв тогтоовол нөхөн сэргээх болон нөхөн олговор зөв тогтоогддог. **Хийсвэрээр нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл тооцдоггүй.**

8. **Дүрвэх, дайжих хүн амыг урьдчилан тооцож нүүлгэн шилжүүлэлтэд хамруулах.** Тайширын УЦС-ын туршлагаас харахад Завхан сумын 3000 хүн амын 1000 нь нүүж таарсан. Албан ёсоор нүүлгэсэн, нөхөн олговор олгосон тоо баримт байхгүй байна. Дам ба хуримтлагдах нөлөөлөлд өртөх хүн амын тоог гаргах, ажилгүйдэл, ядууралд хэрхэн нөлөөлөх үнэлгээг хийлгэх шаардлагатай.
9. **Уламжлалт хүнс, хэрэглээ алдагдсанаас** нутгийн хүм, өрхийн төсөвт учрах хохирол тооцуулах талаар ажлын даалгаварт тусгуулах. Загас, ойн нөөц (мөөг, жимсгэнэ, самар, түлээ) ан гөрөө зэрэг нутгийнхны уламжлалт хэрэглээг нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын даалгаварт тусгуулах.
10. **Зөгийн бэлчээр, загасчлах жуулчлал, амралт сувиллын бизнес, ойн нөхөрлөлийн алдагдлыг тооцуулах, УЦС-ын эдийн засгийн ашгийн тооцооноос хасуулах.** Экологийн цэвэр зөгийн бал, экологийн жуулчлал ирээдүйд улам үнэд орж уурхайгаас илүү ашиг олох боломжтой салбарууд учир “бизнесийн алдагдсан боломж” тооцдог аргачлал тооцож нөхөн олговор үнэлэх талаар Ажлын даалгаварт суулгаж өгөх.
11. **Айл өрхүүдийн “нутгаа алдсан” хохирлыг буюу биет бус хохирлыг үнэлэх, нөхөн олговорт суулгах тухай Нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын даалгаварт оруулах.** Нүүлгэлтэд өртөж өөр нутагт амьдрах болсон хүмүүсийн “нутаг, гал голомт, өвлөж ирсэн болон өвлүүлэх эд хөрөнгө алдсаж байгааг хохиролд тооцдоггүй орхидог. Үүнээс болж их хэмжээний сэтгэл санааны хохирол, дарамт бий болдгийг үнэлүүлэх, үнэлгээнд үндэслэн нөхүүлэх тооцоо хийхийг ажлын даалгарт тусгуулах.
12. **Нүүдэлч мал аж ахуйтны уламжлалаа хадгадах эрхээ эдлэхэд** нь хэрхэн нөлөөлөхийг үнэлгээний даалгаварт тусгаагүй байна.

БО ба экологид нөлөөлөх байдлын үнэлгээнд орхигдсон эрсдлүүдийг үнэлүүлэх:

1. Газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээг **олон улсын стандартын дагуу олон улсын багаар хийлгэх тухай Ажлын даалгаварт суулгах.** УЦС нь 30 давхар байшин шиг өндөр 4.5 тэрбум куб метр ус агуулсан сав буюу томоохон нуур болох юм. Ийм хэмжээний хиймэл усан сан газар хөдлөлтийг өддөг бөгөөд газар хөдлөлтийн хүчийг 1,5 баллаар нэмэгдүүлдэг.
2. **Бүс нутгийн Цэвдэгт** хэрхэн нөлөөлөхийг үнэлэх даалгавар байхгүй. Эг, Шүрэн УЦС-ын барилгын явц болон үйл ажиллагааны хугацаанд цэвдэгт нөлөөлөх үнэлгээ ажлын даалгаварт байхгүй, хөрсд нөлөөлөх байдлын үнэлгээнд орсон эсэх нь тодорхой харагдахгүй байна.
3. **УЦС-ууд барих явцад усны чанар, хүртээмж буурах эрсдлийг** үнэлэх тухай даалгаварт тодорхой тусгаагдаагүй. “Усан сангийн чанар” гэж оруулсан нь хангалтгүй байна.

АСУУЖ БОЛОХ АСУУЛТУУД:

Нүүлгэн шилжүүлэхэд хамаарах асуудлууд:

1. Төслөөс ТАНД учирч болзошгүй сөрөг нөлөө, хохирлыг үнэлэх тухай ажлын даалгаварт тусгагдсан байна уу? Жишээлбэл, таны бэлчээр эсвэл тариалангийн талбай алдагдах бол өөр бэлчээр, тариалангийн талбай олгох боломжит газрын судлагааг хийх даалгавар байна уу?
2. Нүүлгэх боломжит газрын судалгааг бэлчээр ба тариалангийн чиглэлээр ашиглах тоон ба чанарын үнэлгээ хийх даалгавар тусгаагүй байна.

3. Сууринг нүүлгэн шилжүүлэх боломжит газруудын сонголттой хувилбарууд олж судлах даалгавар оруулах уу?
4. Нүүж очих газар оршин суугаа хүн амд учрах нөлөөллийг үнэлэх даалгавар тусгагдсан байна уу?
5. **УЦС ба түүний дэд бүтцэд алдагдах газрыг ямар аргачлаллаар үнэлэх вэ?** Жишээлбэл танай багийн газрыг усанд живүүлэх бол танай бэлчээр, тариалан, хүн амын суурьшлын газруудыг яаж үнэлэх вэ? Ямар аргачлал хэрэглэх вэ? Нутгийнхныг энэ үнэлгээ хийх явцад хэрхэн оролцуулах вэ? Энэ асуудлууд Ажлын Даалгаварт тусгах санал байж болох юм.

УЦС-ын дэд бүтэц ба барилгын шатны нөлөөллийг үнэлэх:

1. УЦС-ын далан 64 м (20 давхар байшин) өндөр, урт нь 1,2 км, доод суурь нь 90 м өргөнтэй томоохон барилга болох юм. Үүнийг барихын тулд ямар хүчин чадал бүхий цемент, бетоны үйлдвэр хаана барих вэ?
2. Танай нутгаас хэдэн тон элс, хайрга зэрэг барилгын материал татах вэ?
3. Хаана хэдэн карьер ухах вэ?
4. Цемент хаанаас татах вэ? Газар хөдлөлтийн 10 баллд тэсвэртэй цемент ашиглах болон далангийн аюулгүй байдлын олон улсын стандартад нийцүүлэх тухай ажлын даалгаварт заасан байна уу?
5. Хаанаас хаашаа хэдэн зам тавих вэ?
6. Усыг хаанаас авч ашиглах вэ?
7. Барилгын шатны ажлын эрчих хүчний хангамж хаанаас ирэх вэ?
8. Өндөр хүчидлийн шугам хаагуур татах вэ?
9. Дэд бүтэц тус бүр дээр байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхээр ажлын даалгаварт тусгасан байна уу?
10. Ажилчдын оршин суух кемп хаана байрлуулах вэ?

Нийгэмд нөлөөлөх байдлыг үнэлэх:

1. УЦС-ын барилгын шатанд танай нутагт шилжиж ирэх ажиллах хүчний тооцоо байна уу?
2. Хаанаас ирэх вэ? Гаднаас ажиллах хүчин олон зуугаар орж ирвэл нийгмийн ямар эрсдэл дагуулахыг судлах, үнэлэх даалгавар байна уу?
3. Охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд ямар эрсдэл учирч болзошгүй үнэлэх даалгаварт байна уу?
4. Томоохон барилгын ажлыг хангах түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох, бетон цемент үйлдвэрлэх явцад агаар, ус, хөрс бохирдож хүн амын эрүүл мэнд, тэр дундаа эмэгтэйчүүд эрүүл мэндээр илүү хохирдог хандлага байгааг судлахаар ажлын даалгаварт орсон байна уу?
5. Гэмт хэргийн эрсдлийн үнэлгээ ажлын даалгаварт байна уу? ОТ болон ажиллах хүчин шинээр ирж суурьшсан газруудын туршлагаас харахад нэг хүйс давамгайлсан орчинд архидалт, садар самуун, гэмт хэрэг гаралт эрс нэмэгддэг бөгөөд эрсдлийн үнэлгээ хийж хэв журам сахиулах хүч нөөцийг нэмэгдүүлэх шаардлага гарсан байдаг.
6. Нэг хүйс давамгайлсан ажиллах хүчин шилжин ирсэн газар бэлгийн замын халдварт өвчлөл нэмэгдэх, хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдлийг үнэлэх даалгавар байна уу?
7. Алдагдах бэлчээрийн талбайн тооцоо байна уу?
8. Хэдэн малчин өрхийн хэдий хэмжээний бэлчээр алдагдах вэ?
9. УЦС-ын дээд ба доод хэсэгт танай сум, багийн хооронд явдаг зам хөдөлгөөнд ямар байдлаар нөлөөлөхийг үнэлэх даалгавар байна уу?

10. УЦС-ын барилга ба усан санг дүүргэх явцад далангаас доош орших хэсгүүдийн усан хангамжинд хэрхэн нөлөөлөх, элийн засаг, эрүүл мэндэд ямар эрсдэл болзошгүйг үнэлэх даалгавар байна уу?
11. Уламжлалт хүнс ба хэрэглээ болох түлээ, жимс, загас г.м. дагалт баялаг ашиглах боломж алдагдахаас ямар эрсдэл болзошгүйг үнэлэх даалгавар байна уу?